



premium



# **Санхүү, үйл ажиллагааны гүйцэтгэлийн товч танилцуулга – 2025 оны 1-р улирал**

---

Премиум Нэксус ХК


MSE: CUMN

2024 оны 4-р сарын 22

1. CU бизнесийн харьцуулсан болон нийт дэлгүүрийн гүйцэтгэл
2. CU бизнесийн стратегийн зорилтууд
3. Бусад охин компаниуд
4. Премиум Нэксус ХК нэгтгэсэн санхүү, үйл ажиллагааны тайлан
  - а) Орлого, үр дүнгийн голлох үзүүлэлт
  - б) Санхүүгийн байдлын тайлангийн гол үзүүлэлт
  - с) Мөнгөн гүйлгээний тайлангийн гол үзүүлэлт
5. Хувьцааны үнийн хөдөлгөөн

▲ Цэвэр борлуулалт /тэрбум төгрөг/

■ Дэлгүүрийн тоо



## Харьцуулсан дэлгүүрийн гүйцэтгэл

|                                           | 2025 1-р улирал |
|-------------------------------------------|-----------------|
| Өдрийн дундаж борлуулалтын өсөлт          | 19.92%          |
| Өдрийн дундаж үйлчлүүлэгчдийн тооны өсөлт | 8.60%           |
| Сагсны үнийн өсөлт                        | 10.42%          |


Харьцуулсан дэлгүүрийн тоо - 361

## Нийт дэлгүүрийн гүйцэтгэл

|                                           | 2025 1-р улирал |
|-------------------------------------------|-----------------|
| Өдрийн дундаж борлуулалтын өсөлт          | 11.58%          |
| Өдрийн дундаж үйлчлүүлэгчдийн тооны өсөлт | 0.75%           |
| Сагсны үнийн өсөлт                        | 10.75%          |

Нийт дэлгүүр дэлгүүрийн тоо: 375 → 466

2025 оны 2-р сараар жилийн инфляц 9.1% байхад харьцуулсан дэлгүүрийн хэрэглэгчдийн сагсны хэмжээ дунджаар 10.4%-аар өссөн нь худалдан авагчдын сагсны хэмжээ бодит 1.3%-ын өсөлт үзүүлснийг харуулж байна.



## Гол онцлох үйл явдлууд

- 25 шинэ дэлгүүр нээж, 4 дэлгүүр хааснаар нийт 466 дэлгүүртэй болсон.
- Улаанбаатар хотод 397, орон нутагт 69 дэлгүүр үйл ажиллагаа явуулж байна.
- Нийт 13 аймагт хүрээгээ тэлсэн.

| Дэлгүүрийн тоо | 2024 | 2025Q1 |
|----------------|------|--------|
| CU             | 445  | 466    |



## 3-р эмнэлэгийн ариун цэврийн өрөөний засварыг хийж гүйцэтгэлээ

Нийгмийн хариуцлагын хүрээнд Шастины нэрэмжит 3-р эмнэлгийн ариун цэврийн өрөөг бүрэн шинэчиллээ. Өдөрт 1500 гаруй хүн үйлчлүүлдэг тус эмнэлгийн ариун цэврийн өрөөнд 30 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, орчин үеийн эмнэлгийн шаардлага хангасан тоног төхөөрөмж суурилуулж, өвчтөнүүдийн тав тух, эрүүл ахуйн стандартыг хангасан цэвэр, цэмцгэр орчныг бүрдүүлж, хүлээлгэн өглөө.



## Хөвсгөл аймагт 3 шинэ салбар нээлээ

CU Конвиниенс дэлгүүр нь Хөвсгөл аймгийг зорин ирэх жуулчид болон нутгийн иргэдэд олон улсын стандарчлагдсан үйлчилгээ хүргэхээр Улаанбаатараас 800 км-ийн зайд байрлах Мөрөн хотод 3 салбар дэлгүүрээ нээлээ.



# Бүтээгдэхүүнээрээ ялгарах



Кимбабны орц найрлага, амт, хэмжээг шинэчлэн илүү олон төрлийг танилцууллаа.



CU-н нэрийн бэйкери бүтээгдэхүүнүүдийг олон сонголттойгоор хүргэж байна.



Хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн чанарын стандартыг хангасан ISO22000, HACCP нэвтрүүлсэн үйлдвэрт хийсэн амтат буузыг зах зээлд нэвтрүүллээ.

## Урт хугацааны лоялти хөтөлбөр

Сэнтрал Коммерс ХХК нь Чингис задгай шар айргийн харилцагч нар дээрээ урт хугацааны лоялти хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн. Харилцагч нартайгаа хамтын ажиллагаагаа сайжруулах, хэрэглэгчид өндөр зэрэглэлийн шар айргийг стандартын дагуу сайн чанартайгаар үйлчлэх тогтмол борлуулалттай харилцагчдыг бэлтгэх зорилготой урт хугацааны хөтөлбөр юм.

## Уг хөтөлбөрийн хүрээнд бий болгож буй үнэ цэнэ:

- Шар айргийг стандартын дагуу хэрэглэгчдэд хүргэх
- Хэрэглэгчдээс санал хүсэлт хүлээн аван алдаа дутагдалаа сайжруулах
- Шар айрагны уух соёлыг стандартчилан хэрэглэгчдээ сургах






## Кейтеринг үйлчилгээ

Үйл ажиллагаагаа өргөжүүлэн шинэ борлуулалтын сувагт үйл ажиллагаагаа тэллээ. Энэхүү шинэ үйлчилгээний хүрээнд салбартаа олон жилийн туршлагатай баг ажиллан өндөр зэрэглэлийн стандартаар хэрэглэгчдэдээ үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Үйлчилгээний үнийн хувьд зах зээлд өрсөлдөхүйц хэрэглэгчдэд боломжийн үнийг санал болгож байна.



## “GET” retail кофе бүтээгдэхүүнийг амжилттай нэвтрүүлэв


- 2025 оны 1-р улиралд Central Coffee Roasting компани нь “GET” нэртэй анхны retail бүтээгдэхүүнээ CU Mongolia сүлжээтэй хамтран амжилттайгаар зах зээлд нэвтрүүллээ.
- Уг бүтээгдэхүүн нь өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд 430 гаруй CU дэлгүүрт худалдаалагдаж байна.
- Энэхүү нэвтрүүлэлт нь брэндийн танигдалтыг нэмэгдүүлэх, хэрэглэгчтэй шууд харьцах сувгийг бий болгох, FMCG сегментэд тэлэх стратегийн эхлэл болж өглөө.





## Технологийн хөгжүүлэлт болон шинэ зах зээлийн холболт:

- Хятадын Алибаба группийн Таобао системийн холболтын албан ёсоор өөрийн систем дээр нэвтрүүлэн 2024 онд хэрэгжиж байсан системийн шийдлийг өндөр түвшинд сайжруулав. Ингэснээр Стора-р дамжуулан Таобао-с дээр бараа бүтээгдэхүүн авах үеийн Хайлтын Илэрц, Хурд, Бүтээгдэхүүний мэдээлэл, Барааны чанарын үзүүлэлтүүдийг шууд татан харах шинэчлэлтийг хийлээ
- АНУ-с илүү өргөн сонголттойгоор бүтээгдэхүүн захиалах боломжийг хангах зорилгоор Apple, Patagonia, Alo, Canadian Goose зэрэг брендүүдээр хүрээгээ тэлэн холболт хийж тус брендийн бүтээгдэхүүнийг төгрөгийн төлбөрийн хэрэгслээр болон зээлээр хуваан төлөх боломжоор хэрэглэгчидээ хангав.
- Хятадын хамгийн том онлайн худалдааны платформ болох JingDong-той албан ёсны хамтралыг эхлүүлэн Хятадын гигант худалдаа тээврийн компанитай хамтран ажиллаж бүтээгдэхүүн үйлчилгээг нь Монголын зах зээл дээр нэвтрүүлэх анхны Монгол компани болов.



## Америкаас хамгийн хурдан, Хятадаас тээвэр, үйлчилгээний төлбөр үнэгүй

Тээврийн хугацаа удах асуудал үүсэхийг багасгах, илүү сайжруулан тав тухтай үйлчилгээ хэрэглэгч нартаа бий болгох зорилгоор 1-р улиралд Америк болон Хятадын тээврийн үйл ажиллагаандаа дараах шинэчлэлтийг нэвтрүүлэв.

- Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний гол тээврийн урсгал явагддаг Эрээн хотод өөрийн агуулахаа нээн хэрэглэгчдийн ачааг илүү нарийн зохицуулах, ангилан ялгах, эвдрэл гэмтэл үүсэхгүй тээвэрлэх нөхцлөөр хангах цаашлаад Хятадаас Монгол руу ирэх тээврийн хугацааг бурууах зорилгоор үйл ажиллагаагаа Эрээн хот руу тэллээ.
- Америкаас ачаа, бараа тээвэрлэх хугацааг илүү богиносгон дунджаар 12-16 хоногт ирдэг байсан хугацааг хэрэглэгч бараа захиалсан хугацаанаас хойш 8-12 хоногт тээвэрлэх боломжийг бий болгов.

## Төлбөрийн илүү олон боломж

- Стора Централ нь Голомт банкны хэрэглээний зээлийг Стора систем дээр нэвтрүүлэхдээ өөрийн үйлчилгээний онцлог тохируулан нэвтрүүлсэн нь хэрэглэгч эхний 14 хоногт хүү төлөхгүй буюу хэрэглэгчийн гар дээр захиалсан бараа тээвэрлэгдэн ирэх хүртэл хүү бодогдохгүй байх нөхцлөөр хангасан зээлийн үйлчилгээг нэвтрүүлэв.
- Хуваан төлөх үйлчилгээ зөвхөн нэг сонголттой байсныг өргөжүүлэн Pocket Zero-той хамтын ажиллагааг эхлүүлэн урьдчилгаа төлбөргүйгээр гадаадаас хүссэн бүтээгдэхүүнээ захиалан авах боломжоор хангав.




| (Сая төгрөгөөр)                | 2023 оны 3-р сарын 31 | 2024 оны 3-р сарын 31 | 2025 оны 3-р сарын 31 |
|--------------------------------|-----------------------|-----------------------|-----------------------|
| Нийт цэвэр борлуулалт          | 71,093.2              | 110,927.5             | 152,194.9             |
| Борлуулалтын өртөг             | 68,214.6              | 95,843.7              | 126,734.1             |
| Нийт ашиг                      | 2,878.6               | 15,083.8              | 25,460.8              |
| Нийт ашгийн хувь               | 4.0%                  | 13.6%                 | 16.7%                 |
| Үйл ажиллагааны зардал         | 2,517.4               | 4,226.0               | 7,929.6               |
| ХТЭХӨАшиг                      | 361.3                 | 10,857.8              | 17,531.2              |
| ХТЭХӨАшгийн хувь               | 0.5%                  | 9.8%                  | 11.5%                 |
| Элэгдэл Хорогдол               | 6,210.4               | 7,961.6               | 9,847.6               |
| Мөнгөн бус зүйлс - Олз/(гарз)  | (91.9)                | 1,248.4               | (102.9)               |
| ХТӨАшиг                        | (5,941.0)             | 4,144.7               | 7,580.7               |
| Санхүүжилтийн зардал           | 4,101.4               | 4,980.7               | 4,890.6               |
| Татварын өмнөх ашиг/(алдагдал) | (10,042.4)            | (836)                 | 2,690.1               |
| Татварын зардал                | (8.0)                 | 1.2                   | (80.6)                |
| Цэвэр ашиг/(алдагдал)          | (10,034.4)            | (837.1)               | 2,770.8               |
| Цэвэр ашгийн хувь              | (14.1)%               | (0.8)%                | 1.8%                  |



# Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

| (Сая төгрөгөөр)                            | 2023 оны 12-р сарын 31<br>/аудитлагдсан/ | 2024 оны 12-р сарын 31<br>/аудитлагдсан/ | 2025 оны 3-р сарын 31<br>/аудитлагдаагүй/ |
|--------------------------------------------|------------------------------------------|------------------------------------------|-------------------------------------------|
| Эргэлтийн хөрөнгө                          | 40,170.3                                 | 78,400.1                                 | 76,507.8                                  |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө            | 2,980.6                                  | 10,431.5                                 | 6,151.0                                   |
| Дансны авлага                              | 641.2                                    | 6,042.3                                  | 4,571.9                                   |
| Бараа материал                             | 28,250.0                                 | 47,194.5                                 | 45,321.8                                  |
| Бусад эргэлтийн хөрөнгө                    | 8,298.5                                  | 14,731.8                                 | 20,463.1                                  |
| Эргэлтийн бус хөрөнгө                      | 153,324.6                                | 235,531.3                                | 250,516.3                                 |
| Биет болон биет бус хөрөнгө                | 90,193.8                                 | 157,907.5                                | 170,155.4                                 |
| Ашиглах эрхтэй хөрөнгө                     | 50,534.8                                 | 60,568.6                                 | 64,478.3                                  |
| Бусад эргэлтийн бус хөрөнгө                | 12,596.0                                 | 17,055.1                                 | 15,882.6                                  |
| <b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>                        | <b>193,494.9</b>                         | <b>313,931.4</b>                         | <b>327,024.1</b>                          |
| Богино хугацаат өр төлбөр                  | 116,172.9                                | 116,262.5                                | 113,474.8                                 |
| Дансны өглөг                               | 42,916.4                                 | 56,829.4                                 | 58,206.1                                  |
| Богино хугацаат зээл                       | 19,970.0                                 | 25,360.3                                 | 20,954.3                                  |
| Бусад богино хугацаат өр төлбөр            | 53,286.5                                 | 34,072.8                                 | 34,314.4                                  |
| Урт хугацаат өр төлбөр                     | 91,590.7                                 | 94,880.1                                 | 107,989.7                                 |
| Урт хугацаат зээл                          | 33,999.7                                 | 23,911.6                                 | 29,571.8                                  |
| Бусад урт хугацаат өр төлбөр               | 57,591.0                                 | 70,968.5                                 | 78,417.9                                  |
| Эздийн өмч                                 | (14,268.7)                               | 102,788.8                                | 105,559.6                                 |
| Энгийн хувьцаа                             | 81,776.9                                 | 111,425.2                                | 111,425.2                                 |
| Нэмж төлөгдсөн капитал                     | 13,820.5                                 | 45,757.9                                 | 45,758.0                                  |
| Эздийн өмчийн бусад хэсэг                  | 318.7                                    | 318.7                                    | 318.7                                     |
| Хяналтын эрхгүй хувь оролцоо               | -                                        | 8,873.4                                  | 9,091.9                                   |
| Хуримтлагдсан алдагдал                     | (110,184.8)                              | (63,586.4)                               | (61,034.2)                                |
| <b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b> | <b>193,494.9</b>                         | <b>313,931.4</b>                         | <b>327,024.1</b>                          |

| (Сая төгрөгөөр)                                                | 2023 оны 3-р сарын 31 | 2024 оны 3-р сарын 31 | 2025 оны 3-р сарын 31 |
|----------------------------------------------------------------|-----------------------|-----------------------|-----------------------|
| Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ                          |                       |                       |                       |
| Мөнгөн орлогын дүн (+)                                         | 84,716.3              | 126,752.0             | 180,994.7             |
| Мөнгөн зарлагын дүн (-)                                        | (79,747.9)            | (123,493.8)           | (162,385.9)           |
| Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн             | 4,968.4               | 3,258.2               | 18,608.8              |
| Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ              |                       |                       |                       |
| Мөнгөн орлогын дүн (+)                                         | 45.8                  | 1,245.1               | 345.3                 |
| Мөнгөн зарлагын дүн (-)                                        | (7,156.1)             | (4,087.8)             | (18,300.2)            |
| Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (7,110.3)             | (2,842.7)             | (17,954.9)            |
| Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ                      |                       |                       |                       |
| Мөнгөн орлогын дүн (+)                                         | 12,800.0              | 8,276.1               | 115,099.7             |
| Мөнгөн зарлагын дүн (-)                                        | (12,987.3)            | (5,778.1)             | (120,011.6)           |
| Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн         | (187.3)               | 2,498.0               | (4,911.9)             |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн гадаад валютын ханшийн зөрүү | (15.3)                | (28.3)                | (22.6)                |
| Бүх цэвэр мөнгөн гүйлгээ                                       | (2,344.5)             | 2,885.2               | (4,280.6)             |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл               | 4,280.7               | 2,980.6               | 10,431.5              |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл              | 1,936.2               | 5,865.8               | 6,150.9               |





Т БАНК

24



Анхаарал  
хандуулсанд  
баярлалаа

Холбоо барих бол:  
IR manager Ц. Номуундалай  
И-мэйл: [investor@cumongol.mn](mailto:investor@cumongol.mn)